



ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

21000, Дорнод аймаг, Хэрлэн сум 7-р баг
ЗДТГ-ын II байр, Утас/Факс: 7058-4203

2020.08.13 № 497

танай _____ -ны № _____ -т

ДОРНОД АЙМГИЙН ЧУЛУУНХОРООТ
СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН СОНГУУЛЬД ОРОЛЦОХ
ЧУЛУУНХОРООТ СУМЫН МАН-ЫН
ДАРГА Д.БАТЖАРГАЛ ТАНАА

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Орон нутгийн Хурлын сонгуульд оролцох Чулуунхороот сумын Монгол ардын намын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох нам нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хууль болон "Алсын хараа-2050"-д нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцооны хамт ирүүлж, хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага нь сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох намын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817 - 1 : 2020 Тулгуур зарчим, Төрийн аудит MNS 6817 - 6 : 2020 Нийцлийн аудитын зарчим, Төрийн аудит MNS 6817 - 8 : 2020 Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2020 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2020-2022 оны төсвийн төсөөллийн тухай хууль болон "Алсын хараа-2050", холбогдох бусад байгууллагаас авсан мэдээллийг шалгуур болгосон.

Дүгнэлт

"Чулуунхороот сумын Монгол ардын нам"-ын сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөр, түүнд орсон зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, "Алсын хараа-2050", Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

"Чулуунхороот сумын Монгол ардын нам"-ын мөрийн хөтөлбөр /.... хуудас/-ийг хавсаргав.

Хувийг: Дорнод аймгийн сонгуулийн хороонд

Хавсралт хуудастай.

ДАРГА БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР _____ БОЛОРТУУЛ



011020575



Чулуунхороот сумын Монгол Ардын Намын хорооны
2020 оны 06 дүгээр сарын 20-ны өдрийн
...4 хуралдааны 01 тоот тогтоолын хавсралт




**ДОРНОД АЙМГИЙН ЧУЛУУНХОРООТ СУМЫН
МОНГОЛ АРДЫН НАМЫН БАЙГУУЛЛАГААС
2020 ОНЫ ОРОН НУТГИЙН ХУРЛЫН СОНГУУЛЬД ОРОЛЦОХ
МӨРИЙН ХӨТӨЛБӨР**

Дорнод аймгийн Чулуунхороот сумын Монгол Ардын намын хорооны
Мөрийн хөтөлбөр нь:

- 1. Хүнээ дээдэлсэн нийгмийн хөгжлийг бий болгоно**
- 2. Эрүүл аюулгүй амьдрах орчныг бүрдүүлнэ.**
- 3. Тогтвортой амьдралын баталгаатай, тэргүүлэх хөгжилтэй сум болно** гэсэн 3 үндсэн зорилтод тулгуурлан тодорхойлж боловсрууллаа.

- Хүн амын эрүүл мэндийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулна
- Боловсролын үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулж хүүхэд, багш, ажилтан нэг бүрийн хөгжлийг дэмжинэ.
- Иргэдийн амьжиргааны түвшинг дээшлүүлэхийг эрмэлзэнэ.
- Хүрээлэн буй орчны бохирдол доройтлыг бууруулж экологийн тэнцвэрт байдлыг хадгална.
- Иргэдийн суурь хэрэгцээг бүрэн хангасан амгалан тайван амьдрах нөхцөлийг бүрдүүлсэн сууринг хөгжүүлнэ
- Хөдөө Аж Ахуйн шинэ технологи бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжинэ.

- Байгаль орчинд сөргөөр нөлөөлөхгүй, дэвшилтэт технологид суурилсан газар тариаланг хөгжүүлнэ.
- Хязгаар нутгийн болон хөрш орнуудыг холбосон дэд бүтцийн том зангилаа боомт болон хөгжүүлэх бодлогыг дэмжинэ.
- Орон нутгийн засаглалын чадавхийг бэхжүүлж, төрийн байгууллагуудын ажлын уялдааг сайжруулна.



Чулуунхороот сум

- Ахуй үйлчилгээний төв байгуулна. / цогцоор нь/
- Монгол дагуурын тусгай хамгаалалттай газрыг түшиглэн байгаль, түүхийн аялал жуулчлалыг хөгжүүлэх, бааз байгуулна.
- Улз голын модон гүүрийг шинэчлэн төмөр бетон гүүр барина.
- Хүүхэд, залуучууд, иргэдийн чөлөөт цагийг өнгөрүүлэх соёл амралтын хүрээлэн болон чөлөөт цагийн төв байгуулна.
- Зүүн Эрээнцавд хүүхдийн цэцэрлэгийн салбар байгуулж, байнгын ажиллагаатай болгоно.
- Сумын төвөөс орох гарах төв замын хэсэгт угталт үдэлтийн хаалга хийнэ
- Сумын төвд орон нутгийг судлах танхим байгуулна.
- Сумын төвийг зүүн Эрээнцавтай холбосон 3,5 км замыг сайжруулна.